

ШУА-ИЙН ХАРЬЯА ХҮРЭЭЛЭН, ТӨВИЙН ЗАХИРЛУУД СОНГОГДЛОО

ШУА-ийн харьяа эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн захирлыг сонгох сонгууль 3 дугаар сарын 10-ны өдөр болж өнгөрлөө. Энэ удаагийн сонгуулиар Физик **технологийн хүрээлэн**, Информатикийн хүрээлэн, Хими, хими технологийн хүрээлэн, Технологийн инкубатор, Байгалийн шинжлэлийн нэгдсэн лаборатори, Биологийн хүрээлэн зэрэг 17 хүрээлэн, төвийн захирлын орон тоон дээр эрдэмтэд нэрээ дэвшүүлэн өрсөлдсөн юм.

Хүрээлэн, төвийн захирлын сонгууль явуулах тухай зарыг өдөр тутмын хэвлэл /Өдрийн сонины №034/-д нийтэлсний дагуу 40 эрдэмтэн нэрээ дэвшүүлж материалаа ирүүлсэн байна. Эдгээр нэр дэвшигчид энэ сарын 10-ны өдөр ШУА-ийн Тэргүүлэгчдийн хурлаар орж цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө буюу мөрийн хөтөлбөрөө танилцуулж хэлэлцүүлээ.

Улмаар *"Шинжлэх ухааны академийн харьяа байгууллагуудын захирлыг сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх журам"*-ын дагуу Академийн Тэргүүлэгчдийн саналыг үндэслэн Академийн Ерөнхийлөгч хүрээлэн, төвийн захирлуудыг сонголоо. Үүнд Хими, хими технологийн хүрээлэнгийн захирлаар тус хүрээлэнгийн захирал, академич Д.Батсүрэн, Технологийн инкубаторийн захирлаар Ч.Батсүх, Биологийн хүрээлэнгийн захирлаар академич Ц.Жанчив, Ботаникийн хүрээлэнгийн захирлаар академич Ч.Дугаржав, Геоэкологийн хүрээлэнгийн захирлаар доктор Ж.Цогтбаатар, Эрдэс боловсруулалт, технологийн хүрээлэнгийн захирлаар доктор Х.Бадамхатан, Түүхийн хүрээлэнгийн захирлаар доктор С.Чулуун, Археологийн хүрээлэнгийн захирлаар доктор Д.Цэвээндорж нар тус тус улиран сонгогдлоо.

Харин Физик технологийн хүрээлэнгийн захирлаар Цөмийн энергийн газрын Цацрагийн хяналтын шинжилгээ, тохируулгын лабораторийн эрхлэгч, доктор Д.Орлох, Одон орон, геофизикийн судалгааны төвийн захирлаар тус төвийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор С.Дэмбэрэл, Информатикийн хүрээлэнгийн захирлаар тус хүрээлэнгийн

Эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор Б.Нэргүй, Байгалийн шинжлэлийн нэгдсэн лабораторийн захирлаар Монгол Германы хамтарсан химийн экологийн лабораторийн эрхлэгч, доктор Д.Гүнбилэг, Газарзүйн хүрээлэнгийн захирлаар тус хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор С.Энх-Амгалан, Геологи, эрдэс баялгийн хүрээлэнгийн захирлаар тус хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор Д.Одгэрэл, Философи, социологи эрхийн хүрээлэнгийн захирлаар тус хүрээлэнгийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч, доктор Г.Чулуунбаатар, Олон улс судлалын хүрээлэнгийн захирлаар тус хүрээлэнгийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч, доктор Д.Шүрхүү, Палеонтологийн төвийн захирлаар тус төвийн лабораторийн эрхлэгч, доктор Х.Цогтбаатар нар тус тус шинээр томилогдов.

Хүрээлэн, төвийн захирлын бүрэн эрхийн хугацаа хуульд зааснаар 4 жил байдаг бөгөөд шинээр болон улиран сонгогдсон захирлууд бүрэн эрхийнхээ хугацаанд хийж гүйцэтгэх ажлын гэрээг ШУА-ийн ерөнхийлөгчтэй байгуулах юм.